



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

“Евразиа капитал холдинг” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Евразиа капитал холдинг” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог 50,000,000 /тавин сая/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 52,270,892 /тавин хоёр сая хоёр зуун далан мянга найман зуун ерэн хоёр/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-г үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Евразиа капитал холдинг” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд 90 төгрөгөөс доошгүй үнээр тэргүүн ээлжинд худалдан авахыг хуульд заасан журмын дагуу санал болгон зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Евразиа капитал холдинг” ХК /Г.Оюунболд/-д зөвшөөрсүгэй.

3. “Евразиа капитал холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдах авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр нийтэд санал болгохыг зөвшөөрсүгэй.

4. “Евразиа капитал холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг худалдан авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр зохион байгуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/, “Евразиа капитал холдинг” ХК /Г.Оюунболд/-д тус тус үүрэг болгосугай.

5. Нэмж үнэт цаас гаргасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Евразиа капитал холдинг” ХК /Г.Оюунболд/-д үүрэг болгосугай.

1/ Компани нэмж хувьцаа гаргасантай холбоотойгоор компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх, бололцоог хангах;

00112

2/ Бүртгүүлсэн боловч эргэлтэнд гаргаагүй буюу зарласан хувьцааг үнэт цаасны танилцуулгад заасан хуваарийн дагуу зах зээлд байршуулах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь тогтмол хүргүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



ЗНАРАНТУЯА